



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэмандал сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/174/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaa.T@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Нэргүйбаатар Утас: 70332860 Цахим хаяг: Nerguibaatar.d@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Цог-Эрдэнэ Утас: 99210906 Цахим хаяг: Tsogerdene.g@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Аудитын дүгнэлт

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/ ба илэрсэн зөрчилд зөвлөмж хүргүүллээ.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	15
4.2 Албан шаардлага	15
4.3 Зөвлөмж	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

ЭРДЭНЭМАНДАЛ СУМЫН ИТХ-ЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА П.УУГАНБАЯР
ТАНАА

№ _____
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэмандал сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Эрдэнэмандал сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 27 төлөөлөгчдөд тойрогт ажиллах, хууль тогтоомж сурталчлах арга хэмжээнд зориулж 4,475.000 төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн Сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,526,400	928,200
2	БАРАА МАТЕРИАЛ	1,526,400	928,200
3	Хангамжийн материал	1,526,400	928,200
4	Бичиг хэргийн материал	457,400	
5	Аж ахуйн материал	1,069,000	928,200
6	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,075,931.09	8,143,203.29
7	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,075,931.09	8,143,203.29
8	Биет хөрөнгө	4,075,931.09	8,143,203.29
9	Авто-тээврийн хэрэгсэл		5,000,000
10	Машин тоног төхөөрөмж(компьютер)	6,679,600	6,679,600
11	Хуримтлагдсан элэгдэл	-2,733,876.67	-3,536,396.71
12	Тавилга, аж ахуйн эд хогшил	2,674,900	2,674,900
13	Хуримтлагдсан элэгдэл	-2,544,692.24	-2,674,900
14	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,602,331.09	9,071,403.29
15	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,602,331.09	9,071,403.29
16	Засгийн газрын хувь оролцоо	5,602,331.09	9,071,403.29
17	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,292,500	1,292,500
18	Хуримтлагдсан үр дүн	4,309,831.09	7,778,903.29
19	Өмнөх үеийн үр дүн	420,357.84	4,309,831.09
20	Тайлант үеийн үр дүн	3,889,473.25	3,469,072.2
21	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,602,331.09	9,071,403.29

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	өмнөх он	тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	73,226,200	76,166,300
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		5,000,000
3	Нийтлэг татварын бус орлого		5,000,000
4	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		5,000,000
5	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	73,226,200	71,166,300
6	Нэмэлт санхүүжилтийн орлого		540,000
7	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		540,000
8	Орон нутгийн төсвөөс санхүүжих	73,226,200	70,626,300
9	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	73,226,200	70,626,300
10	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	69,336,726.75	72,697,227.8
11	УРСГАЛ ЗАРДАЛ	69,336,726.75	72,697,227.8
12	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	62,799,835.75	66,444,053.8
13	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	49,201,267	49,243,330.5
14	Үндсэн цалин	49,201,267	49,243,330.5
15	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,090,042	6,310,795.5
16	Тэтгэврийн даатгал	4,169,780	4,414,181.32
17	Тэтгэмжийн даатгал	492,014	453,416.5
18	ҮОМШӨ-ний даатгал	393,610	400,956.48
19	Ажилгүйдлийн даатгал	94,058	86,645.4
20	Эрүүл мэндийн даатгал	940,580	955,595.8
21	Хангамж, бараа материалын зардал	3,647,328	3,072,160
22	Бичиг хэрэг	1,000,700	1,149,200
23	Тээвэр, шатахуун	1,999,928	1,103,160
24	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,000	300,000
25	Ном, хэвлэл	286,700	200,000
26	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000	60,000
27	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		259,800
28	Томилолт, зочны зардал	718,000	1,200,000
29	Дотоод албан томилолт	718,000	1,200,000
30	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,020,072	3,145,540
31	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,500,072	2,805,540
32	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000	140,000
33	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000	200,000
34	Бараа үйлчилгээний бусад зардал	1,123,126.75	3,472,227.8
35	Бараа үйлчилгээний бусад зардал	900,000	1,999,500
36	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		540,000
37	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	223,126.75	932,727.8
38	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,536,891	6,253,174
39	Бусад урсгал шилжүүлэг	4,977,000	5,900,000
40	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,977,000	5,900,000
41	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,559,891	353,174
42	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,559,891	353,174
43	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,889,473.25	3,469,072.2
44	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	3,889,473.25	3,469,072.2

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,292,500	420,357.84	1,712,857.84
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,292,500	420,357.84	1,712,857.84
3	Тайлант үеийн үр дүн		3,889,473.25	3,889,473.25
4	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,292,500	4,309,831.09	5,602,331.09
5	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,292,500	4,309,831.09	5,602,331.09
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,292,500	4,309,831.09	5,602,331.09
7	Тайлант үеийн үр дүн		3,469,072.2	3,469,072.2
8	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,292,500	7,778,903.29	9,071,403.29

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	өмнөх он	тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	73,226,200	71,166,300
2	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	73,226,200	71,166,300
3	Нэмэлт санхүүжилтийн орлого		540,000
4	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		540,000
5	Орон нутгийн төсвөөс санхүүжих	73,226,200	70,626,300
6	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	73,226,200	70,626,300
7	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	69,213,600	71,166,300
8	УРСГАЛ ЗАРДАЛ	69,213,600	71,166,300
9	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	62,676,709	64,913,126
10	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	49,204,700	49,204,700
11	Үндсэн цалин	49,204,700	49,204,700
12	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,086,609	6,349,426
13	Тэтгэврийн даатгал	4,118,509	4,425,486.62
14	Тэтгэмжийн даатгал	492,000	492,000
15	ҮОМШӨ-ний даатгал	393,600	362,733.09
16	Ажилгүйдлийн даатгал	98,400	106,291.49
17	Эрүүл мэндийн даатгал	984,100	962,914.8
18	Хангамж, бараа материалын зардал	3,647,400	2,479,000
19	Бичиг хэрэг	987,400	600,000
20	Тээвэр, шатахуун	2,000,000	1,200,000
21	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,000	300,000
22	Ном, хэвлэл	300,000	200,000
23	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000	60,000
24	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		119,000
25	Томилолт, зочны зардал	718,000	1,200,000
26	Дотоод албан томилолт	718,000	1,200,000
27	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,020,000	3,140,000
28	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,500,000	2,800,000
29	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000	140,000
30	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000	200,000
31	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000	2,540,000
32	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000	2,000,000
33	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		540,000
34	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,536,891	6,253,174
35	Бусад урсгал шилжүүлэг	4,977,000	5,900,000
36	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,977,000	5,900,000
37	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,559,891	353,174
38	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,559,891	353,174
39	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,012,600	
40	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,012,600	
41	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,012,600	
42	Дотоод эх үүсвэрээр	4,012,600	
43	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,012,600	
44	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-4,012,600	
45	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		
46	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
47	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	70,626,300	70,273,126	(353,174.0)	99.5
2	УРСГАЛ ЗАРДАЛ	70,626,300	70,273,126	(353,174.0)	99.5
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	64,726,300	64,373,126	(353,174.0)	99.5
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	49,204,700	49,204,700	-	100.0
5	Үндсэн цалин	49,204,700	49,204,700	-	100.0
6	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,642,600	6,349,426	(293,174.0)	95.6
7	Тэтгэврийн даатгал	4,674,500	4,425,486.62	(249,013.4)	94.7
8	Тэтгэмжийн даатгал	492,000	492,000	-	100.0
9	ҮОМШӨ-ний даатгал	393,600	362,733.09	(30,866.9)	92.2
10	Ажилгүйдлийн даатгал	98,400	106,291.49	7,891.5	108.0
11	Эрүүл мэндийн даатгал	984,100	962,914.80	(21,185.2)	97.8
12	Хангамж, бараа материалын зардал	2,479,000	2,479,000	-	100.0
13	Бичиг хэрэг	600,000	600,000	-	100.0
14	Тээвэр, шатахуун	1,200,000	1,200,000	-	100.0
15	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,000	300,000	-	100.0
16	Ном, хэвлэл	200,000	200,000	-	100.0
17	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000	60,000	-	100.0
18	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	119,000	119,000	-	100.0
19	Томилолт, зочны зардал	1,200,000	1,200,000	-	100.0
20	Дотоод албан томилолт	1,200,000	1,200,000	-	100.0
21	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,200,000	3,140,000	(60,000.0)	98.1
22	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,800,000	2,800,000	-	100.0
23	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000	140,000	(60,000.0)	70.0
24	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	200,000	200,000	-	100.0
25	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000	2,000,000	-	100.0
26	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000	2,000,000	-	100.0
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,900,000	5,900,000	-	100.0
28	Бусад урсгал шилжүүлэг	5,900,000	5,900,000	-	100.0
29	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,900,000	5,900,000	-	100.0
30	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	70,626,300	70,273,126	(353,174.0)	99.5

Эрдэнэмандал сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ			-	
32	Улсын төсвөөс санхүүжих			-	
33	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	63,426,300	70,273,126	6,846,826.0	110.8
34	Орон нутгийн төсвөөс	63,426,300	70,273,126	6,846,826.0	110.8
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,200,000		(7,200,000.0)	-
36	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	7,200,000		(7,200,000.0)	-
38	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
39	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
40	АЖИЛЛАГСАДЫН ТОО	2	2	-	100.0
41	Удирдах ажилтан	1	1	-	100.0
42	Гүйцэтгэх ажилтан	1	1	-	100.0
43	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	2	2	-	100.0
44	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1	1	-	100.0
45	Улс төрийн албан хаагч (УТ)	1	1	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөг /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	540,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	540,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	540,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	540,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	540,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	540,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	540,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	540,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эрдэнэмандал сумын ИТХ нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн дансны хууль тогтоомжийг мөрдөн мэдээллийг хуулинд заасан хугацаанд Шилэн дансаар олон нийтэд мэдээлж хэвшихтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Цог-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэмандал сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эрдэнэмандал сумын ИТХ нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1-д “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ажлын албатай байна”, 54.2-д “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, орон тоо, цалингийн санг Засгийн газраас тогтоосон хязгаарын хүрээнд Хурал өөрөө тогтооно”, 54.3-д “Ажлын албаны дарга нь тухайн Хурлын нарийн бичгийн дарга байх бөгөөд орон тооны байна” гэж заасны дагуу харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулдаг, аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд *“Сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэхэд иргэдийн бүтээлч санаачлага, идэвхтэй оролцоо, төлөөлөх эрхийг нэмэгдүүлэн хүний хөгжлийг бүх талаар хангах боломж нөхцлийг бий болгох, нутгийн өөрөө удирдах ёсыг хөгжүүлэх, бие даасан эрхзүйн орчныг бүрдүүлэх”* гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын нэгжтэй, санхүүгийн үйл ажиллагаанд 3 чиглэлээр хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, аудитын албанаас төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэмандал сумын ИТХ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 70.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 0.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 0.5 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 3.4 сая төгрөгөөр буюу 38.2 хувиар өсч материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая.төгрөгөөр/			
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Бараа материал	1.53	0.93	(0.60)	(64.44)
Үндсэн хөрөнгө	4.08	8.14	4.07	49.96
Нийт хөрөнгө	5.60	9.07	3.47	38.25
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5.60	9.07	3.47	38.24
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5.60	9.07	3.47	38.24

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын үлдэгдэл 64.4 хувиар буурсан байна.

Бараа материалын данс нь 1.5 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 3.1 сая төгрөгөөр нэмэгдэж, 3.7 сая төгрөгийн зарцуулалтаар, буурч оны эцэст 0.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 49.9 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 4.0 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд сумын ЗДТГ-аас 5.0 сая төгрөгийн автомашин шилжиж ирсэн дүнгээр нэмэгдсэн, хасагдсан хөрөнгө байхгүй ба байгуулсан 0.9 сая төгрөгийн элэгдлээр буурч оны эцэст 8.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүн 3.4 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт / сая.төгрөгөөр/
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт -/орон нутгийн төсөв/	73.23	70.63	(2.60)
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	0.54	0.54
Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө	-	5.00	5.00
Үйл ажиллагааны орлого	73.23	76.17	2.94
Цалин, шимтгэлийн зардал	49.20	49.24	0.04
Бусад бараа үйлчилгээний зардал	13.60	17.20	3.60
Урсгал шилжүүлэг	6.54	6.25	(0.28)
Үйл ажиллагааны зардал	69.34	72.70	3.36
Үйл ажиллагааны бус зардал /ҮХХ-ны гарз/	-	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	3.89	3.47	(0.42)

Эрдэнэмандал сумын ИТХ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 2.6 сая төгрөгөөр буюу 3.5 хувиар буурсан нь хангамжийн бараа материалын зардал 32 хувиар, тээвэр шатахууны зардал 40 хувиар, мэдээлэл технологийн зардал 50 хувиар тус тус буурсантай холбоотой байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зардлыг 74.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 3.5 сая төгрөгөөр бууруулж, зардлыг 70.6 сая төгрөгөөр хянаж баталсан байна. Харин тайлант онд батлагдсан төсөвт тодотгол хийсэн боловч өөрчлөлт ороогүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 70.6 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авч, 100 хувь зарцуулалт хийсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 0.5 сая төгрөгийн орлого төвлөрч сумын ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхижуулах сургалтанд зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 12 дугаар сарын 24-ны өдөр Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан ба 2022 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 6 үндсэн зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 94.7 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 70.6 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 100 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд орон тоо нэмэгдүүлээгүй, шагнал урамшуулал олгоогүй, автомашин, албан конторын тавилга, албаны болон дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж хэрэгсэл худалдан аваагүй байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/ ба илэрсэн зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Эрдэнэмандал сумын ИТХ нь 2021 онд 141 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 138 мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 10% буюу 1.3 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43-р тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлагыг хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилты холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар албан хаагчдын ХХОАТ-ын хөнгөлөлтийг зөрүүтэй тооцож олгосон, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй зөрчил илэрсэнд цалингийн шимтгэлийг үнэн зөв тооцох, дотоод хяналтыг тогтмол хэрэгжүүлж үр дүнг тооцож ажиллах 2 заалт бүхий зөвлөмж хүргүүлснийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4.5 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлэн, 5.3 сая төгрөгийн зөрчилд 21 заалт бүхий зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 4.5 сая төгрөгийн алдаа нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 0.7 сая төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.2 Албан шаардлага

- Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас сумын ИТХ-ын 27 төлөөлөгчдөд тойрогт ажиллах, хууль тогтоомж сурталчлах арга хэмжээнд 4.4 сая төгрөгийг зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 -д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн Сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дэх заалт болон Сангийн Сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлэх

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 9 нэр төрлийн 5.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил байгаа бөгөөд тус хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр заалтын дагуу ашиглалтын хугацаа дууссан, ашиглагдахгүй болсон хөрөнгийг Сангийн сайдын 388-р тушаалын НББ-ийн дансны зааврын 4.39-т заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллах

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
			Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал												
1	Эрдэнэмандал сумын ИТХ	Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 9 нэр төрлийн 5.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил байна.	1	5.3							1	5.3
2		Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас сумын ИТХ-ын 27 төлөөлөгчдөд тойрогт ажиллах, хууль тогтоомж сурталчлах арга хэмжээнд 4.4 сая төгрөгийг зарцуулсан.	1	4.4					1	4.4		
Дүн			2	9.7					1	4.4	1	5.3
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал												
1	Эрдэнэмандал сумын ИТХ	10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 10% буюу 1.3 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй.	1	1.3					1	1.3		
2		141 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 138 мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроосон байна.	1								1	
Дүн			2	1.3					1	1.3	1	
Нийт дүн			4	11.0					2	5.7	2	5.3